



**МОНГОЛБАНК**  
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

**МӨНГӨ, САНХҮҮГИЙН  
СТАТИСТИК**  
2021 оны 3 дугаар сар

Улаанбаатар хот



# 1 МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ


## 1.1 Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт

Мөнгөний нийлүүлэлт (M2 мөнгө) өмнөх оны мөн үеэс **22.9 хувиар өсч 25.1 их наяд төгрөгт хүрлээ**. M2 мөнгөний жилийн өсөлтийн 16.9 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 3.4 нэгж хувийг төгрөгийн харилцах, 3.4 нэгж хувийг гадаад валютын хадгаламж, 0.8 нэгж хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө, -1.6 нэгж хувийг гадаад валютын харилцах тус тус бүрдүүлж байна. Өмнөх сартай харьцуулахад мөнгөний нийлүүлэлт 2.0 хувиар өсөхөд иргэдийн төгрөгийн харилцах, хадгаламж, хувийн байгууллагын харилцах, гадаад валютын хадгаламж нэмэгдсэн нь нөлөөлсөн байна. Харин иргэдийн гадаад валютын хадгаламж буурчээ.


## 1.2 Хадгаламж

**Нийт хадгаламжийн хэмжээ 18.5 их наяд төгрөг** байгаагаас 85.5 хувь буюу 15.9 их наяд

Зураг 1-1: M2 мөнгө өмнөх оны мөн үеэс 22.9%-иар нэмэгдсэн байна.



Зураг 1-3: M2 мөнгө өмнөх сараас 2.0 хувиар өсөв.




төгрөг нь иргэдийн, 14.5 хувь буюу 2.7 их наяд төгрөг нь байгууллагын хадгаламж байна. Нийт хадгаламжийн 23.6 хувь нь гадаад валютын хадгаламж байна. Үүнээс иргэдийн хадгаламжийн 21.2 хувийг, байгууллагын хадгаламжийн 37.8 хувийг гадаад валютын хадгаламж бүрдүүлж байна.


## 1.3 Мөнгөний нийлүүлэлтийн байршуулалт

Мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл, Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын дотоод цэвэр актив (ДЦА)-ын дүн 18.6 их наяд төгрөг, гадаад цэвэр актив (ГЦА)-ын дүн 6.5 их наяд төгрөгтэй тус тус тэнцэж байна. Өмнөх оны мөн үеэс M2 мөнгөний өсөлтийн 19.1 нэгж хувийг ГЦА, 3.8 нэгж хувийг ДЦА бүрдүүлж байна.

Зураг 1-2: Нийт хадгаламж өмнөх оны мөн үеэс 28.7%-иар өсчээ.



Зураг 1-4: M2 мөнгөний жилийн өсөлтийг ГЦА-ын өсөлт бүрдүүлж байна.



Эх сурвалж: Монголбанк


## 2 БАНКУУДЫН ЗЭЭЛ

### 2.1 Зээлийн өсөлт


Банкуудын зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс **2.8 хувиар өсч 17.5 их наяд төгрөгт хүрсэн** байна. Тодруулбал өмнөх оны мөн үеэс хувийн байгууллагын зээл 3.2 хувиар буурч 8.1 их наяд төгрөгт, иргэдийн зээл 4.4 хувиар өсч 8.9 их наяд төгрөгт хүрчээ. Нийт зээлийн үлдэгдлийн 1.6 их наяд төгрөг буюу 9.2 хувь нь гадаад валютаар олгосон зээл байна.

Өмнөх сартай харьцуулахад зээлийн үлдэгдэл 494.2 тэрбум төгрөг буюу 2.9 хувиар нэмэгдсэн нь иргэдийн зээл 4.3 хувиар, хувийн байгууллагын зээл 1.5 хувиар өссөн нь нөлөөлсөн байна. Харин банкуудаас МИК ОССК-д шилжүүлсэн иргэдийн ипотекийн зээлийг нэмж тооцвол нийт зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 2.4 хувиар, өмнөх сараас 2.3 хувиар нэмэгдсэн байна.

Зураг 2-1: Нийт зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 2.8 хувиар буурч 17.5 их наяд төгрөг болов.



Зураг 2-3: Тайлант сард 2,408.6 тэрбум төгрөгийн зээл олгогдож, 1,910.1 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдлөө.



### 2.2 Зээл олголт, эргэн төлөлт


Тайлант сард шинээр олгосон зээл өмнөх сараас 1,017.8 тэрбум төгрөгөөр, эргэн төлөгдсөн зээл 544.4 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ. Шинээр олгосон зээлийн 6.5 хувь буюу 155.8 тэрбум төгрөгийг гадаад валютаар олгожээ.

### 2.3 Чанаргүй зээл


Чанаргүй зээлийн 73.8 хувийг, хугацаа хэтэрсэн зээлийн 78.0 хувийг хувийн байгууллагын зээл бүрдүүлж байна. **Чанаргүй зээлийн үлдэгдэл 2,013.4 тэрбум төгрөгт** хүрч өмнөх сартай харьцуулахад 3.4 тэрбум төгрөгөөр өссөн байна. Чанаргүй зээлийн 11.6 хувь нь гадаад валютын зээл байна. Чанаргүй зээлийн 20.6 хувийг уул уурхай, 19.3 хувийг боловсруулах, 13.5 хувийг барилга, 10.7 хувийг үл хөдлөх, 7.5 хувийг худалдааны салбарын зээл тус тус эзэлж байна.

Зураг 2-2: Нийт зээлийн 11.5% нь чанаргүй зээл, 7.3% нь хугацаа хэтэрсэн зээл байна.

Тайлбар: \* үйл ажиллагаа явуулж буй 12 банкаар



Зураг 2-4: Чанаргүй зээлийн 73.8% байгууллагын, 25.6% иргэдийн зээл байна.




Эх сурвалж: Монголбанк

2.4 Хувийн байгууллагын зээл


Хувийн байгууллагын зээлийн үлдэгдэл тайлант сард 121.0 тэрбум төгрөгөөр өсчээ.

Хувийн байгууллагын зээлийн үлдэгдлийн сарын өөрчлөлтийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ангилан харуулбал, худалдааны салбарын зээл 71.1 тэрбум, тээвэр агуулахын үйл ажиллагааны салбарын зээл 38.0 тэрбум, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарын зээл 17.5 тэрбум төгрөгөөр тус тус өсч, боловсруулах салбарын зээл 41.9 тэрбум, барилгын салбарын зээл 9.3 тэрбум, уул уурхайн салбарын зээл 3.8 тэрбум төгрөгөөр тус тус буурчээ. Тайлант сард хувийн байгууллагад 1,128.4 тэрбум төгрөгийн зээл шинээр олгогдсоны 13.1 хувь буюу 147.3 тэрбум төгрөгтэй тэнцэх зээл гадаад валютаар олгогджээ.

Зураг 2-5: Хувийн байгууллагын зээлийн үлдэгдлийн дийлэнх хувийг худалдаа, барилга, боловсруулах болон уул уурхайн салбарын зээл бүрдүүлж байна.



Зураг 2-7: Тайлант сард хувийн байгууллагад худалдаа, уул уурхайн салбарт дийлэнх зээл олгогдсон байна



\*Цахилгаан хий, усан хангамж, газар тариалан, мэдээлэл холбоо, санхүү даатгал, мэргэжлийн ШУ, захиргаа, төрийн удирдлага, боловсрол, эрүүл мэнд гэх мэт салбарууд


2.5 Иргэдийн зээл

Тайлант сард иргэдийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 368.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.


Иргэдийн зээлийг задалж авч үзвэл, өмнөх сараас ипотекийн зээлийн үлдэгдэл 73.2 тэрбум (МИК-д шилжсэн багцыг оруулснаар), хадгаламж барьцаалсан зээлийн үлдэгдэл 87.0 тэрбум, худалдааны салбарын зээл 57.8 тэрбум төгрөгөөр, цалин, тэтгэврийн зээлийн үлдэгдэл 8.6 тэрбум төгрөгөөр, картын зээлийн үлдэгдэл 5.6 тэрбум төгрөгөөр тус тус өсч, автомашины зээлийн үлдэгдэл 6.1 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Тайлант сард иргэдэд 1,224.6 тэрбум төгрөгийн зээл шинээр олгогдсоны 0.7 хувь нь гадаад валютаар олгогджээ.

Зураг 2-6: Иргэдийн зээлийн үлдэгдлийн 42.0% (МИК-д шилжүүлсэн багцыг оруулснаар)-ийг орон сууцны зээл, 24.0%-ийг цалин тэтгэврийн зээл бүрдүүлэв.



Зураг 2-8: Тайлант сард иргэдэд олгосон зээлийн ихэнх хувийг хадгаламж барьцаалсан болон цалин, тэтгэврийн зээл эзэлж байна.



\*ХАА, газар тариалан, боловсруулах, цахилгаан хий, усан хангамж, тээвэр агуулах, үйлчилгээ, мэдээлэл холбоо, мэргэжлийн ШУ, захиргаа, төрийн удирдлага, боловсрол, эрүүл мэнд гэх мэт салбарууд

Эх сурвалж: Монголбанк

### 3 ИПОТЕКИЙН ЗЭЭЛ


#### 3.1 Ипотекийн зээлийн үлдэгдэл

2021 оны 3 дугаар сарын байдлаар **100,867 зээлдэгч нийт 5,020.3 тэрбум төгрөгийн** ипотекийн зээлтэй байна. Үүнээс хөтөлбөрийн эх үүсвэрээр **75,570 зээлдэгч 3,749.2 тэрбум төгрөгийн зээл авсан.** Ипотекийн зээлийн үлдэгдлийн **74.7 хувь нь хөтөлбөрийн хүрээнд, 21.7 хувь нь банкуудын өөрийн эх үүсвэрээр, 3.6 хувь нь бусад эх үүсвэрээр олгосон зээл байна.**


#### 3.2 Орон сууцны байршил

Нийт **ипотекийн зээлийн 17.0 хувь буюу 851.7 тэрбум төгрөгийн зээл орон нутагт** ногдож байна. Орон нутгийн ипотекийн зээл<sup>1</sup>-ийн **76.2 хувь нь хөтөлбөрийн хүрээнд, 21.7 хувь нь банкны өөрийн эх үүсвэрээр, 2.1 хувь нь бусад эх үүсвэрээр олгогджээ.**

Зураг 3-1: Ипотекийн зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт 8.2% байна.



Зураг 3-3: Нийт зээлийн 17.0% буюу 851.7 тэрбум төгрөг орон нутагт ногдож байна.



#### 3.3 Ипотекийн зээлийн чанарын үзүүлэлт

Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн **93.9 хувь нь хэвийн**, 1.3 хувь нь хугацаа хэтэрсэн, 4.8 хувь нь чанаргүй зээл байна. Чанаргүй ангилалд шилжсэн ипотекийн зээлийн **65.3 хувийг хөтөлбөрийн зээл, 34.3 хувийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 0.4 хувийг бусад эх үүсвэрийн зээл эзэлж байна.**

#### 3.4 Эх үүсвэр

Тайлант сард **1870 зээлдэгчид 149.6 тэрбум төгрөгийн** ипотекийн зээл шинээр олгосон бөгөөд үүний **71.5 хувийг хөтөлбөрийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн байна.**

Зураг 3-2: Өмнөх сараас хугацаа хэтэрсэн зээл 67.2 тэрбум төгрөгөөр буурч, чанаргүй зээл 20.6 тэрбум төгрөгөөр өсөв.



Зураг 3-4: Тайлант сард шинээр 1870 зээлдэгчид ипотекийн зээл шинээр олгожээ.



Эх сурвалж: Монголбанк

<sup>1</sup> Уг зээл нь орон нутгийн банкны салбараас олгосон бус худалдан авсан орон сууцны байршлаар тооцсон.


3.5 Ипотекийн зээлийн хүү

Тухайн сард шинээр олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 3.5 нэгж хувиар буурч, өмнөх сараас 2.1 нэгж хувиар буурч 8.0 хувьд хүрсэн байна.


3.6 Барьцаа хөрөнгө

Ипотекийн зээлээр борлуулагдсан орон сууцны 88.8 хувийг 80 хүртэлх мкв талбайтай байр бүрдүүлж байна.

Зураг 3-5: Шинээр олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү 8.0 хувьтай байна.



Зураг 3-6: Ипотекийн зээлийн барьцаа хөрөнгийн үнэлгээ талбайн хэмжээгээр




3.7 Орон сууцнууд ашиглалтад орсон оноор

Ипотекийн зээлээр борлуулагдсан орон сууцны 75.5 хувийг 2011 оноос хойш баригдсан орон сууц бүрдүүлж байгаа бөгөөд энэ нь нийт ипотекийн зээлийн 80.0 хувийг эзэлж байна.


3.8 Зээлдэгчдийн орлогын тархалт

2.5 сая төгрөг хүртэлх өрхийн орлоготой иргэд нийт зээлдэгчдийн 72.1 хувийг, нийт зээлийн үлдэгдлийн 57.9 хувийг тус тус бүрдүүлж байна.

Зураг 3-7: Ипотекийн зээлээр борлуулагдсан орон сууцны 75.5 хувийг 2011 оноос хойш ашиглалтад орсон орон сууц бүрдүүлж байна.



Зураг 3-8: Ипотекийн зээл авсан зээлдэгчийн орлогын тархалт




Эх сурвалж: Монголбанк

## 4 ХҮҮ

### 4.1 Шинээр татсан хадгаламжийн хүү

Тайлант сард нийт **шинээр татсан төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) 6.8 хувь, гадаад валютын хадгаламжийн ЖДХ 2.2 хувь** байна. Төгрөгийн хадгаламжийн ЖДХ өмнөх оны мөн үеэс 4.3 нэгж хувиар, валютын хадгаламжийн ЖДХ өмнөх оны мөн үеэс 3.2 нэгж хувиар тус тус буурчээ. Шинээр татсан төгрөгийн хугацаатай хадгаламжийн хүү 7.5 хувь байгаа бол хугацаагүй хадгаламжид хүү тооцогдохгүй байна.


Зураг 4-1: Шинээр татсан төгрөгийн хадгаламжийн хүү өмнөх сараас 0.3 нэгж хувиар буурчээ.




### 4.2 Шинээр олгосон зээлийн хүү

Тайлант сард **шинээр олгосон төгрөгийн зээлийн ЖДХ 15.4 хувь, гадаад валютын зээлийн ЖДХ 8.6 хувьд** хүрчээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад төгрөгийн зээлийн хүү 1.2 нэгж хувиар, валютын зээлийн хүү 1.9 нэгж хувиар буурчээ. Иргэдэд олгосон төгрөгийн зээлийн ЖДХ 15.7 хувь, хувийн байгууллагад олгосон төгрөгийн зээлийн ЖДХ 15.3 хувь байна.


Зураг 4-2: Шинээр олгосон төгрөгийн зээлийн хүү 15.4% байна.



Зураг 4-3: Шинээр татсан хугацаатай хадгаламжийн хүү 7.5%, хугацаагүй хадгаламж хүүгүй байна.



Зураг 4-4: Шинээр олгосон зээлийн хүүний тархалт



Эх сурвалж: Монголбанк


4.3 Үлдэгдлээр хадгаламжийн хүү

Нийт төгрөгийн хадгаламжийн үлдэгдэлд ЖДХ 7.9 хувьтай байна. Харин нийт гадаад валютын хадгаламжийн ЖДХ өмнөх оны мөн үеэс 1.7 нэгж хувиар буурч 2.9 хувьд хүрчээ. Иргэдийн төгрөгийн хадгаламжийн ЖДХ 8.3 хувь, гадаад валютын хадгаламжийн хувьд 3.5 хувьтай байгаа бол хувийн байгууллагын төгрөгийн хадгаламжийн ЖДХ 5.0 хувь байна.

4.4 Хүүний зөрүү

Тухайн сард шинээр олгосон төгрөгийн зээл болон тухайн сард шинээр татсан төгрөгийн хадгаламжийн хүүний зөрүү 8.6 нэгж хувьд хүрэв.

Зураг 4-5: Үлдэгдлээр жигнэсэн нийт төгрөгийн хадгаламжийн хүү 7.9%, иргэдийнх 8.3% байна.




4.5 Зээлийн үлдэгдлээр хүү


Төгрөгийн зээлийн үлдэгдлийн ЖДХ 16.4 хувь, гадаад валютын зээлийн ЖДХ 9.9 хувьтай байна. Үүнээс иргэдийн төгрөгийн зээлийн үлдэгдлийн ЖДХ 17.5 хувь, гадаад валютын зээлийн ЖДХ 12.1 хувь байна. Хувийн байгууллагын төгрөгийн зээлийн ЖДХ 15.1 хувь, гадаад валютын зээлийн хүү 9.9 хувь байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 46.0 хувь нь 2 хүртэлх жилийн дотор төлөгдөж дуусах зээл байна.


Зураг 4-6: Иргэдийн зээлийн үлдэгдлийн хүү өмнөх оны мөн үеэс 0.7 нэгж хувиар буурчээ.



Зураг 4-7: Хадгаламж, зээлийн хүүний зөрүү өмнөх оноос 3.1 нэгж хувиар өсчээ.



Зураг 4-8: Зээлийн үлдэгдэл, хугацаагаар






## 5 ИНФЛЯЦ

### 5.1 Улсын инфляц

Хэрэглээний үнийн улсын индекс 2021 оны 3 дугаар сарын байдлаар сарын инфляц 0.6 хувь, **жилийн 2.5 хувь** байна. Жилийн инфляцыг авч үзвэл 2.1 нэгж хувийг хүнсний бараа, 0.4 нэгж хувийг хүнснээс бусад барааны үнийн өсөлт бүрдүүлж байна.


Зураг 5-1: Улсын жилийн инфляц 2.5 хувьтай байна.



### 5.2 Улаанбаатар хотын инфляц

Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс 3 дугаар сарын байдлаар сарын 0.7 хувь, **жилийн 2.0 хувь** байгаа ба 2.4 нэгж хувийг хүнсний бараа, -0.4 нэгж хувийг хүнснээс бусад бараа бүрдүүлж байна. Хүнсний барааны бүлгийн үнийн өсөлтөд мах, махан болон сүү, сүүн бүтээгдэхүүний бүлгийн үнийн өсөлт, хүнснээс бусад барааны үнэ буурахад хэрэглээний нүүрсний үнэ болон бензиний үнэ буурсан нь нөлөөлжээ.

Зураг 5-2: УБ хотын жилийн инфляц 2 хувьд хүрэв.




Эх сурвалж: ҮСХ

## 6 ХАНШ

### 6.1 Ам.долларын ханш

Төгрөгийн ам.доллартой харьцах ханш сарын эцсийн байдлаар 2,849.81 төгрөгт хүрсэн нь **өмнөх сарын эцсээс 0.02 хувиар**, өмнөх оны мөн үеэс 2.6 хувиар суларсан үзүүлэлт байна. Тайлант сарын дундаж ханш нь 2,849.64 төгрөг байв.


Зураг 6-1: Төгрөгийн ам.доллартой харьцах ханшийн өөрчлөлт. жилийн өсөлт %



### 6.2 Хятадын юанийн ханш

Төгрөгийн юаньтай харьцах сарын эцсийн ханш **өмнөх сараас 1.4 хувиар чангарч** 434.44 төгрөгт хүрэв. Тухайн сарын хамгийн бага ханш нь 433.59 төгрөг байсан бол хамгийн өндөр ханш нь 441.03 төгрөг байлаа.

Зураг 6-2: Төгрөгийн юаньтай харьцах ханшийн өөрчлөлт. жилийн өсөлт %




Эх сурвалж: Монголбанк


ХАВСРАЛТ

1. МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

Зураг 1.1. М2 мөнгөний сарын өсөлтийн бүтэц




Зураг 1.2. Нөөц мөнгөний бүтэц




2. ЗЭЭЛ


Зураг 2.1. Зээлийн үлдэгдэл, жилийн өсөлт




Зураг 2.2. Зээлийн жилийн өсөлтийн задаргаа /сектороор/




Зураг 2.3. Иргэдийн зээлийн жилийн өсөлтийн задаргаа /зээлийн төрлөөр/



Зураг 2.4. Хувийн байгууллагын зээлийн жилийн өсөлтийн задаргаа /салбараар/



Зураг 2.5. Тайланд сард шинээр олгосон болон төлөгдсөн зээл



Зураг 2.6. Тайлант сард шинээр олгосон зээл (салбараар)




Зураг 2.7. Чанаргүй, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл




Зураг 2.8. Чанаргүй зээлийн дүн /тэрбум ₮/



Зураг 2.9. ЖДҮ эрхлэх зориулалтаар олгосон зээлийн үлдэгдэл




Зураг 2.10. ЖДҮ-ийн зээл дэх чанаргүй зээлийн хувь, салбараар




Зураг 2.11. Хувийн байгууллагад шинээр олгосон зээлийн бүтэц




Зураг 2.12. Орон нутагт шинээр олгосон, төлөгдсөн зээл



Зураг 2.13. Орон нутгийн зээлийн үлдэгдэл




Зураг 2.14. Орон нутгийн чанаргүй зээлийн эзлэх хувь




### 3. ИПОТЕКИЙН ЗЭЭЛ


Зураг 3.1. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь, аймгуудаар



Зураг 3.2. Тухайн сард нийслэл хотод олгогдсон ипотекийн зээл, орон сууцны байршлаар



Зураг 3.3. Тухайн сард орон нутагт олгогдсон ипотекийн зээл, орон сууцны байршлаар



Зураг 3.4. Ипотекийн зээл авсан зээлдэгчийн насны ангиллаарх зээлийн үлдэгдэл

